



Түрэг, харгалзах

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Д.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2019.02.25 № 06/337
танай -ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага ажил хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартыг нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын Засаг захирлын Санхүүгийн тасгийн зурвас журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эргэнцэрэн, санхүүгийн тасгагч нарын хамтаралтай бүрэн илэрхийлэгдэх ангид ажил хийжээ үндэслэлтэй байгаагаа эхлээд өөрөө мэдэгдэж гүйцэтгэлийг цаардсан.

Аудитаар Эрүүл мэндийн ажлын төсвийн тасгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үндэслэл ажил гүйцэтгэлийг дэлгэрэнгүй болон нягт тодруулга бүр байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн баазын бүртгэл хөдөлгө програм хангамж дотоод хяналтын систем болон үндэслэлтэй ажил гүйцэтгэлийг гүйцэтгэж аудитын санал дүгнэлтийг дэмжж ажил гүйцэтгэлийг цаардсан.

Бүтэцтэй үндэслэл бүртгэл бүр мөрдөж байгаа төсвийн тасгийн зурвас журам, зааврын дагуу гүйцэтгэж ажил гүйцэтгэлийг цаардсан.

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн удирдлага Д.Ганцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 11-нээс 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, Д.Болор-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн хөгжлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 87 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь "Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлэх;
- статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрх зүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
- эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх;
- эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх;
- байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Донорын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2018 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвд "Эд эрхтэн шилжүүлэх донорын алба" шинээр байгуулагдаж, ажиллах орон тоо нэмэгдсэн.


2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Тус байгууллагын төсвийн санхүүжилтийн 80 хувь нь гадаад, дотоод сургалтын зардал эзэлдэг тул нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны нийт зардал 5,502,045.5 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 55,020.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	15,000.0	
3	Албан шаардлага өгсөн	4	21,987.5	
	Дүн	7	36,987.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/519, А/539 дүгээр тушаалаар тайлант хугацааны гадаад сургалтын зардлын мөнгийг Төрийн сангийн харилцах данс хаагдах өдөр харьяа 11 байгууллагад шилжүүлсэн байна.

Энэ нь "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5; 6 дугаар зүйлийн 6.4.1; 7 дугаар зүйлийн 7.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтууд тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын холбогдох заалтыг хэрэгжүүлэн, санхүүгийн сахилга батыг чанд сахиж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Мөнгөн хөрөнгө

Харилцах данснаас кассаар дамжуулан 545,397.6 мянган төгрөгийн тэтгэлэг, 151,320.2 мянган төгрөгийн сургалт, 73,491.8 мянган төгрөгийн томилолтын зардлыг тус тус их хэмжээгээр зарцуулсан, мөнгөн хөрөнгийн кассын журнал хөтлөөгүй.

Энэ нь "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1; Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг хэвшүүлэн ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй салбарын нягтлан бодогчдын сургалтыг 21,505.0 мянган төгрөгөөр хэт их өндөр төсөв батлуулан зориулалт бус зардлаас санхүүжүүлж төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлөвлөгөөнд тусгагдаагүй сургалтыг санхүүжүүлэхгүй байх, төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй нийтийн зориулалттай шороон талбайг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалд дахин үнэлгээ хийх аргачлал батлагдаагүй гэсэн үндэслэлээр үнэлгээ хийгдээгүй, хуримтлагдсан элэгдлээ нөхөж үлдэх өртөггүй болсон нь газар үнэгүйдэх эрсдэл үүсэж байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Оршин байх” батламж мэдэгдлүүдтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалыг тус тус үндэслэн шороон талбай /газар/-г үнэлгээнд хамруулах, нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлэх.

5. Балансын данстай холбоотой асуудал

Тайлант хугацааны эцэст түлш халаалтын зардлаас 2,000.0 мянга, томилолтын зардлаас 13,000.0 мянга нийт 15,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй, зориулалтын бус зардлаас шатахуун авч нөөцөлсөн.

Энэ нь “Хэмжилт”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1; 7 дугаар зүйлийн 7.3, 7.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг баримталж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1 дэх заалтуудыг үндэслэн төлбөрийн акт тогтоох.

6. Санхүүгийн тайлангийн аудитын явцад хийсэн залруулга

Санхүүгийн тайлангийн болон завсрын аудитаар төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, нягтлан бодох бүртгэлийн програм хангамж, батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудад илэрсэн алдаанд залруулга хийлээ. Үүнд:

- 6.1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн авлагын дансанд Нийгмийн даатгалын шимтгэлийн 2018 оны 12 дугаар сарын тайлангийн 2,622.5 мянган төгрөгийг бүртгэлгүй орхигдуулсан. Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал”

- батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг нийцэхгүй байна.
- 6.2. Байгууллагын нийт 55,354.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шинж чанараар нь зөрүүлэн ангилж бүртгэсэн. Энэ нь "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 86 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- 6.3. Өмнөх оны 24,740.9 мянган төгрөгийн авлагын эцсийн үлдэгдлийн дүн санхүүгийн програмын алдаанаас шалтгаалан 2019 оны санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдэлд тусгагдаагүй. Энэ нь "Үнэн зөв байдал" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтуудыг үндэслэн залруулгуудыг хийв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2017-2018 онд тайлант хугацааны эцэст эмч, эмнэлгийн ажилтныг мэргэшүүлэх гадаадын сургалтад төсөвлөсөн хөрөнгийн үлдэгдлийг Сангийн яаманд "хураалгах"-гүйн тулд оны эцэст дээд шатны байгууллагын шийдвэрээр Төрийн сангийн гүйлгээ хаагдах өдөр бусад байгууллагуудад шилжүүлсэн мөн үндсэн хөрөнгө худалдан авахдаа Эрүүл мэндийн сайдын 2016 оны "Зардал гаргах тухай" 203 дугаар тушаал буюу тушаалын үндэслэл буруу шийдвэрээр зориулалтын бус зардлаас хөрөнгө бэлтгэсэн зэрэг асуудлууд анхаарал татахуйц байлаа.

Дараагийн аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх эмч, эмнэлгийн ажилтныг мэргэшүүлэх гадаадын сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтыг хамруулах нь зүйтэй гэж үзэж байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 7 чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 4,657,919.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 4,619,282.6 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна.

Тус төв үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 55,766.3 мянган төгрөг буюу 110.9 хувиар давуулан биелүүлсэн байна.



2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн хөгжлийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад дахин нягталж үзэхэд 96 хувьтай байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Үйл ажиллагааны орлогыг үйлчилгээ үзүүлсэн нэр төрлөөр ангилан бүртгээгүй, тус төвийн 2 дугаар байрны байрлагчдын бүртгэлийг тодорхой бус бүртгэж байгаа зэрэгт тавих хяналт сул байна.

Энэ нь “Иж бүрэн”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1; 20.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын анхан шатны баримтыг нэр төрлөөр нь ангилан бүртгэж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2. Удирдлагын болон дотоод хяналттай холбоотой асуудал

Дотоод хяналт, санхүү, захиргааны албаны даргын үүргийг нэг албан тушаалтан гүйцэтгэж байгаагаас санхүүгийн хяналт суларсан, байгууллагын хяналтын хараат бус байдал алдагдсан байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр, 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311, 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төсөв захирагчийн дэргэд дотоод хяналт, дотоод аудитын /нэгж/ үндсэн ажилтны орон тоонд багтаан ажиллуулах зөвлөмж өгөх.

2.17 Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153,571,580.00	147,636,669.00
33	АВЛАГА	23,740,942.91	11,664,770.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	11,664,770.00
35	БАРАА МАТЕРИАЛ	129,830,637.72	135,971,899.00
351	Түүхий эд материал	27,653,922.00	32,513,500.00
35110	Тусгай зориулалттай материал	8,243,950.00	1,925,000.00
35130	Эм боох материал	19,409,972.00	30,588,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	84,625,887.00	00.00
354	Хангамжийн материал	17,550,828.72	103,458,399.00
35410	Бичиг хэргийн материал	6,951,324.00	2,936,276.00
35420	Аж ахуйн материал	129,530.00	1,038,245.00
35430	Сэлбэг хэрэгсэл	645,000.00	9,013,454.00
35440	Түлш, шатах тослох материал	7,924,000.00	16,450,160.00
35450	Барилгын засварын материал	1,900,974.72	2,968,584.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	71,051,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,670,129,980.10	1,984,894,402.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,670,129,980.10	1,984,894,402.13
392	Биет хөрөнгө	1,596,293,979.15	1,849,873,296.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,599,564,415.00	1,479,086,220.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,502,217,418.32	-482,964.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,793,120.00	89,833,120.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-79,833,120.08	-61,868,120.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,231,768,484.89	1,253,670,958.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-855,317,195.25	-1,043,978,229.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	259,233,938.00	316,661,563.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-175,631,734.34	-190,545,308.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,712,000.00	17,409,713.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,546,666.75	-14,681,813.00
39217	Ном	4,768,156.00	4,768,156.00
393	Биет бус хөрөнгө	73,836,000.95	135,021,105.95
39301	Програм хангамж	86,677,093.55	89,427,093.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	-45,136,592.60	-60,677,147.60
39303	Бусад биет бус хөрөнгө	32,295,500.00	106,271,160.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,823,701,560.73	2,132,531,071.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	230,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	230,000.00
413	Өглөг	00.00	230,000.00
4136	Бусад өглөг	00.00	230,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	10,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	220,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,823,701,560.73	2,132,301,071.13
51	Засгийн газрын хувь оролцоо	1,823,701,560.73	2,132,301,071.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,390,485,153.08	2,390,485,153.08
51101	Өмч: - төрийн	-886,474,054.63	-886,474,054.63
51102	- хувийн	3,276,959,207.71	3,276,959,207.71
512	Хуримтлагдсан үр дүн	-566,783,592.35	-1,122,654,413.25
51210	Өмнөх үеийн үр дүн	-566,783,592.35	-589,330,955.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-533,323,457.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	864,470,331.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,823,701,560.73	2,132,531,071.13

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,360,814,239.14	4,968,722,021.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	467,328,444.62	820,802,521.03
120	Нийтлэг татварын бус орлого	467,328,444.62	591,439,396.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	461,730,604.62	585,282,066.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	358,761,104.62	446,634,036.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,969,500.00	112,384,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	26,263,530.00
120009	Бусад орлого	5,597,840.00	6,157,330.00
122	Тусламжийн орлого	00.00	229,363,124.73
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	31,900,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	197,463,124.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,893,485,794.52	4,147,919,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,655,553,900.00	4,147,919,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,655,553,900.00	4,147,919,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	237,931,894.52	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,618,268,165.39	5,129,941,990.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,452,547,850.16	5,129,941,990.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,452,547,850.16	5,017,742,405.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	896,291,396.72	862,458,697.87
210101	Үндсэн цалин	896,291,396.72	862,458,697.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,822,690.77	102,483,259.91
210201	Тэтгэврийн даатгал	64,123,216.48	72,572,536.22
210202	Тэтгэмжийн даатгал	7,483,532.74	4,656,900.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,609,177.44	6,800,472.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,911,282.76	1,861,216.03
210205	Эрүүл мэндийн даатгал	15,695,481.36	16,592,134.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,026,428.78	82,886,375.95
210301	Гэрэл, цахилгаан	37,038,567.78	37,071,389.30
210302	Түлш, халаалт	24,050,717.00	25,235,948.00
210303	Цэвэр, бохир ус	15,937,144.00	20,579,038.65
2104	Хангамж, бараа материалын зардал	93,307,073.64	103,799,210.00
210401	Бичиг хэрэг	39,153,554.60	41,938,717.00
210402	Тээвэр, шатахуун	13,724,800.00	15,943,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,587,924.04	14,021,394.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,920,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,369,300.00	8,894,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,676,120.00	21,080,809.00
210408	Бараа материал акталсны зардал	14,795,375.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	2,856,200.00

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,856,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,442,977.88	50,491,809.72
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,141,500.00	00.00
210604	Урсгал засвар	30,301,477.88	50,491,809.72
2107	Томилолт, зочны зардал	20,874,611.00	44,511,381.00
210702	Дотоод албан томилолт	20,874,611.00	44,511,381.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,611,505.00	276,130,469.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,822,165.00	186,907,839.70
210803	Даатгалын үйлчилгээ	903,300.00	1,040,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,200.00	151,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	48,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,796,100.00	25,985,500.00
210807	Газрын төлбөр	418,000.00	525,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,543,740.00	61,471,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,993,171,166.37	3,492,125,001.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	47,768,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,662,161,870.72	3,125,728,709.99
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	331,009,295.65	318,627,761.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,720,315.23	112,199,584.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	7,997,541.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	7,997,541.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	104,202,043.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	104,202,043.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	165,720,315.23	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,720,315.23	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-257,453,926.25	-161,219,969.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,000,977.10	372,103,488.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,000,977.10	45,928,053.22
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	326,175,435.13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,000,977.10	-372,103,488.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-258,454,903.35	-533,323,457.90



4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,360,352,684.17	4,912,644,930.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,810,652.62	764,725,430.69
120	Нийтлэг татварын бус орлого	460,810,652.62	575,780,574.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	455,212,812.62	565,766,328.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,943,312.62	452,631,828.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,269,500.00	113,134,500.00
120009	Бусад орлого	5,597,840.00	10,014,246.40
122	Тусламжийн орлого	00.00	188,944,855.99
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	188,944,855.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,899,542,031.55	4,147,919,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,655,553,900.00	4,147,919,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,655,553,900.00	4,147,919,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	243,988,131.55	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	243,988,131.55	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,302,638,740.17	4,820,750,015.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,302,638,740.17	4,820,750,015.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,108,615,434.94	4,696,885,660.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879,779,014.00	845,395,700.00
210101	Үндсэн цалин	691,466,314.00	653,118,100.00
210102	Нэмэгдэл	87,501,100.00	91,469,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,808,600.00	100,808,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,718,318.00	101,678,000.00
210201	Тэтгэврийн даатгал	92,718,318.00	67,862,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	8,454,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,763,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,690,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	16,907,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,006,428.78	84,576,375.95
210301	Гэрэл, цахилгаан	37,018,567.78	37,071,389.30
210302	Түлш, халаалт	24,050,717.00	26,925,948.00
210303	Цэвэр, бохир ус	15,937,144.00	20,579,038.65
2104	Хангамж, бараа материалын зардал	65,594,251.04	79,222,106.00
210401	Бичиг хэрэг	27,406,152.00	18,727,794.00
210402	Тээвэр, шатахуун	10,198,200.00	10,822,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,587,924.04	14,271,394.00
210404	Ном, хэвлэл	00.00	10,020,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,131,416.00	12,392,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,270,559.00	12,987,628.00
2105	Нормативт зардал	354,000.00	37,549,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	354,000.00	37,549,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,684,620.00	48,492,035.00

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,766,300.00	398,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,540,000.00
210604	Урсгал засвар	28,918,320.00	46,554,035.00
2107	Томилолт, зочны зардал	20,874,611.00	57,511,381.00
210702	Дотоод албан томилолт	20,874,611.00	57,511,381.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	268,362,321.40	271,248,532.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,971,731.40	206,089,852.97
210803	Даатгалын үйлчилгээ	903,300.00	1,040,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,200.00	151,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	48,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,271,300.00	32,564,380.00
210807	Газрын төлбөр	418,000.00	525,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,669,790.00	30,829,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,671,241,870.72	3,171,211,929.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	21,505,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,671,241,870.72	3,149,706,929.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,026,305.23	123,864,354.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,310,000.00	7,997,541.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	7,997,541.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,310,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	115,866,813.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	115,866,813.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	170,716,305.23	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	170,716,305.23	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>57,713,944.00</u>	<u>91,894,915.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	57,713,944.00	91,894,915.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,713,944.00	91,894,915.00
2200	Дотоод эх үүсвэрээр	57,713,944.00	91,894,915.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	57,713,944.00	91,894,915.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-57,713,944.00</u>	<u>-91,894,915.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

01
 ТӨСВИЙН АУДИТЫН БАРИЛГА
 ЗӨРЧИЛГҮҮЛ
 САНАА ДҮГНЭХ/Т

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	00.00	-308,328,689.00	2,082,156,464.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	00.00	-308,328,689.00	2,082,156,464.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	258,454,903.35	258,454,903.35
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	00.00	-566,783,592.35	1,823,701,560.73
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	00.00	-566,783,592.35	1,823,701,560.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-22,547,363.00	-22,547,363.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	00.00	-589,330,955.35	1,801,154,197.73
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	864,470,331.30	00.00	864,470,331.30
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-533,323,457.90	-533,323,457.90
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	-1,122,654,413.25	2,132,301,071.13

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэлийн	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,657,919,500.00	4,619,282,630.92	38,636,869.08	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,657,919,500.00	4,619,282,630.92	38,636,869.08	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,649,919,500.00	4,611,285,089.92	38,634,410.08	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,395,700.00	845,395,700.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	653,118,100.00	653,118,100.00	00.00	100.0
210102	Нэмэгдэл	91,469,000.00	91,469,000.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,808,600.00	100,808,600.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,447,600.00	101,447,600.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	67,631,700.00	67,631,700.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,454,000.00	8,454,000.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,763,200.00	6,763,200.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,690,800.00	1,690,800.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,907,900.00	16,907,900.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,787,300.00	84,576,375.95	7,210,924.05	92.1
210301	Гэрэл, цахилгаан	37,991,500.00	37,071,389.30	920,110.70	97.6
210302	Түлш, халаалт	31,995,800.00	26,925,948.00	5,069,852.00	84.2
210303	Цэвэр, бохир ус	21,800,000.00	20,579,038.65	1,220,961.35	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	77,198,800.00	75,026,531.00	2,172,269.00	97.2
210401	Бичиг хэрэг	19,304,900.00	18,727,794.00	577,106.00	97.0
210402	Тээвэр, шатахуун	10,840,000.00	10,822,500.00	17,500.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,569,200.00	14,271,394.00	297,806.00	98.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,742,500.00	12,392,790.00	349,710.00	97.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,742,200.00	18,812,053.00	930,147.00	95.3
2105	Нормативт зардал	39,485,100.00	37,549,600.00	1,935,500.00	95.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	39,485,100.00	37,549,600.00	1,935,500.00	95.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,827,800.00	134,562,525.00	1,265,275.00	99.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,250,000.00	47,154,290.00	95,710.00	99.8
210602	Тавилга	39,000,000.00	38,954,200.00	45,800.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	1,900,000.00	1,100,000.00	63.3
210604	Урсгал засвар	46,577,800.00	46,554,035.00	23,765.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	58,021,200.00	57,511,381.00	509,819.00	99.1
210702	Дотоод албан томилолт	58,021,200.00	57,511,381.00	509,819.00	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	258,943,300.00	250,569,652.97	8,373,647.03	96.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,727,300.00	206,089,852.97	3,637,447.03	98.3

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	2,852,200.00	1,040,100.00	1,812,100.00	36.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	871,200.00	151,600.00	719,600.00	17.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	185,100.00	48,100.00	137,000.00	26.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,895,000.00	11,885,500.00	9,500.00	99.9
210807	Газрын төлбөр	742,500.00	525,500.00	217,000.00	70.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,670,000.00	30,829,000.00	1,841,000.00	94.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,041,812,700.00	3,024,645,724.00	17,166,976.00	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,505,000.00	21,505,000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,020,307,700.00	3,003,140,724.00	17,166,976.00	99.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,000,000.00	7,997,541.00	2,459.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00	7,997,541.00	2,459.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,000,000.00	7,997,541.00	2,459.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,657,919,500.00	4,619,282,630.92	38,636,869.08	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,147,919,500.00	4,043,502,056.22	104,417,443.78	97.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,147,919,500.00	4,043,502,056.22	104,417,443.78	97.5
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	10,014,246.40	-10,014,246.40	
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	10,014,246.40	-10,014,246.40	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	510,000,000.00	565,766,328.30	-55,766,328.30	110.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	410,000,000.00	452,631,828.30	-42,631,828.30	110.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.00	113,134,500.00	-13,134,500.00	113.1
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	00.00	00.00	00.00	00.0
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	00.00	00.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	75	74	00.00	00.0
620001	Удирдах ажилтан	02	01	00.00	00.0
620002	Гүйцэтгэх ажилтан	61	61	00.00	00.0
620003	Үйлчлэх ажилтан	12	12	00.00	00.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/402/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/519, А/539 дүгээр тушаалаар тайлант хугацааны гадаад сургалтын зардлын мөнгийг Төрийн сангийн харилцах данс хаагдах өдөр харьяа 11 байгууллагад шилжүүлсэн байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий захирал Ахлах нягтлан бодогч	Д.Ганцэцэг Б.Очир
2	Харилцах данснаас кассаар дамжуулан 545,397.6 мянган төгрөгийн тэтгэлэг, 151,320.2 мянган төгрөгийн сургалт, 73,491.8 мянган төгрөгийн томилолтын зардлын мөнгийг тус тус их хэмжээгээр зарцуулсан, мөнгөн хөрөнгийн кассын журнал хөтлөөгүй.	-	Албан шаардлага хүргүүлэх	Ахлах нягтлан бодогч	Д.Гантуяа /асан/ Б.Очир
3	Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй салбарын нягтлан бодогчдын сургалтыг 21,505.0 мянган төгрөгөөр хэт их өндөр төсөв батлуулан эдийн засгийн ангилал зөрүүлэн санхүүжүүлж төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн.	21,505.0	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий захирал Ахлах нягтлан бодогч	Э.Содном жамц Д.Гантуяа
4	Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй нийтийн зориулалттай шороон талбайг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалд дахин үнэлгээ хийх аргачлал батлагдаагүй гэсэн үндэслэлээр үнэлгээ хийгдээгүй, хуримтлагдсан элэгдлээрээ нөхөж үлдэх өртөггүй болсон нь газар үнэгүйдэх эрсдэл үүсч байна.	482.5	Албан шаардлага хүргүүлэх	Ахлах нягтлан бодогч	Б.Очир
5	Тайлант хугацааны эцэст түлш халаалтын зардлаас 2,000.0 мянга, томилолтын зардлаас 13,000.0 мянга нийт 15,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй, шатахуун авч нөөцөлсөн.	15,000.0	Акт тогтоох	Ахлах нягтлан бодогч	Б.Очир

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Үйл ажиллагааны орлогыг үйлчилгээ үзүүлсэн нэр төрлөөр ангилан бүртгээгүй, тус төвийн 2 дугаар байрны байрлагчдын бүртгэлийг тодорхой бус бүртгэж байгаа зэрэгт тавих хяналт сул байна.	-	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Б.Очир
7	Дотоод хяналт, санхүү, захиргааны албаны даргын үүргийг нэг албан тушаалтан гүйцэтгэж байгаагаас санхүүгийн хяналт суларсан, байгууллагын хяналтын хараат бус байдал алдагдсан байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий захирал	Д.Ганцэцэг
8	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн авлагын дансанд Нийгмийн даатгалын шимтгэлийн 2018 оны 12 дугаар сарын тайлангийн 2,622.5 мянган төгрөгийн авлагыг бүртгэлгүй орхигдуулсан.	2,622.5	Залруулга хийсэн	Ерөнхий захирал Ахлах нягтлан бодогч	Д.Ганцэцэг Б.Очир
9	Байгууллагын нийт 55,354.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шинж чанараар нь зөрүүлэн ангилж бүртгэсэн.	55,354.8	Залруулга хийсэн		
10	Өмнөх оны 24,740.9 мянган төгрөгийн авлагын эцсийн үлдэгдлийн дүн санхүүгийн програмын алдаанаас шалтгаалан 2019 оны санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдэлд тусгагдаагүй.	24,740.9	Залруулга хийсэн		
11	ЭМХТ-ийн хөрөнгө шинээр бэлтгэх тушаалын үндэслэл буруу тушаалаар 12,324.4 мянга, төсөв захирагчийн тушаал шийдвэргүй 71,980,6 мянга буюу нийт 84,305.0 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бэлтгэсэн.		Зөвлөмж өгөх	Ерөнхий захирал Ахлах нягтлан бодогч	Д.Ганцэцэг Б.Очир
	Дүн	119,705.7			